

ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Д.Ганбат

*ХСНХ-н Ахисан Шатны Боловсролын Сургуулийн
Гэмт явдал судлалын магистрант цагдаагийн ахмад*

Монгол Улсад 1925 онд нисэх хүчин үүсч хөгжсөн бөгөөд 1957 оны 2-р сарын 19-ний өдөр Цэрэг ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэргийг Эрхлэх Яамны сайдын 107 тоот тушаалаар Улаанбаатар хотын Буянт-Ухаа нисэх онгоцны төв буудал анх байгуулагдсан байна.

1958 онд Ил-14 онгоцоор Улаанбаатараас Эрхүү, Бээжингийн чиглэлд олон улсын нислэг хийдэг болсноор “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал болж, улмаар 2005 оны 12-р сарын 21-ний өдөр Монгол улсын Засгийн газрын 255 дугаар тогтоолоор “Чингис хаан” Олон Улсын нисэх буудал болгон өөрчилсөн байна.

Монгол Улсад Иргэний агаарын тээвэр үүссэн цагаас нисэх буудлын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хэв журмын сахиулах ажлыг цагдаагийн байгууллага гүйцэтгэж ирсэн билээ.

1941 оны 8 дугаар сард Ардын Сайд нарын Зөвлөлийн 39 дүгээр тогтоол¹-оор улсын эдийн засаг, улс төрийн ач холбогдолтой газруудын хамгаалалтыг цагдан сэргийлэх байгууллагад шууд хариуцхаар болгож харуулын албаны олон жижиг анги салбаруудыг нэг удирдлаганд төвлөрүүлэн нэгтгэж, орон тоо, шат дамжлагыг цомхотгон ажлыг шуурхай болгох зорилгоор ахмад Лувсан-Осорын Дэндэв даргатай гэрээт харуулын хэлтэс, лейтенант Уртнасангийн Цэвээндорж даргатай сэргийлэн хамгаалах хэлтэс, Улаанбаатар хотод байсан харуулын 3 суманг тус тус нэгтгэж харуулын дивизион байгуулж даргаар нь сумангийн дарга ахлах лейтенант Цэндийн Жагзавыг томилсон нь Иргэний Агаарын Тээврийн харуул хамгаалалтын эхлэл байжээ.

Тус дивизион байгуулагдсанаар аймгуудын цагдаа нарын орон тоог нэмэгдүүлэн, аймаг хотуудын банк, радио станц, нисэх онгоцны буудал, консулын газрууд, зарим чухал склад агуулах болон соёлын төв газрууд, Ерөө, Лүнгийн гүүрүүдийг хамгаалдаг болгожээ. 1942 онд Налайхын нарийн төмөр зам, 1943 онд Сүхбаатар, Уртын дамжлага бааз, Улаанбаатарын ноосны үйлдвэр, Мах комбинат, зэрэг төв орон нутгийн чухал чухал газруудыг ардын цагдан сэргийлэхийн хамгаалалтанд нэмэн өгчээ.²

1925-1950-иад онд нисэх хүчин улс эх орныхоо аюулгүй байдал, батлан хамгаалах үүргийг голлон гүйцэтгэж байсан тул сөргөлдөгч талын хорлон сүйтгэх үйл ажиллагааг илрүүлэн урьдчилан сэргийлж, таслан зогсоох ажлыг УАХБ нисэх хүчинтэй хамтран зохион байгуулж ирсэн дайчин уламжлалтай билээ.

Энэ хугацаанд Буянт-Ухаад зорчигч тээврийн үйлчилгээ төвлөрөн зохион байгуулагдсан, нисэх буудалд үйлчилгээний дэг журам сахиулах, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх шинэ зорилт бий болсноор тухайн үеийн төр засаг, намын бодлого шийдвэр иргэний агаарын

¹ Улсын байгууллагууд ба аж үйлдвэрийн газруудыг цагдан сэргийлэхээс гэрээгээр хамгаалах журам болон тэнд ажиллаж байгаа дарга цагдаа нарын цалин хэрэглэл, хувцас форм, ахуй хангамжийн тухай

² 114-115 дугаар хуудас

тээврийн нислэг зорчигч үйлчилгээний талаар тодорхой асуудлууд тусгагдан хэрэгжиж байсан бөгөөд дотоод гадаадын нислэг үйлчилгээнд гарсан хэрэг, зөрчил, осол сүйрлийн үед Монголын цагдаагийн байгууллага мэргэжлийн бусад албатай хамтран ажиллаж байжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1978 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудлыг Цагдан сэргийлэхийн гэрээт хамгаалалттай болгохыг Нийгмийг Аюулаас хамгаалах Яаманд даалгасны дагуу БНМАУ-ын Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1979 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 67 тоот тушаалаар хошууч Ж.Дондов даргатайгаар Нисэхийн Цагдан сэргийлэх группийг үүсгэн байгуулсан байна.

Энэхүү өдрийг Нисэхийн Цагдаагийн Хэлтсийн үүсэн байгуулагдсан өдөр гэж тооцож авч үзвэл 37 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байна.

1980 онд МАХН-ын Төв Хорооны УТТ-ны 23, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 32 дугаар тогтоолуудыг үндэслэн Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны Сайдын 606 тоот тушаалаар дээрхи цагдан сэргийлэх группийг цагдан сэргийлэх анги болгон өргөжүүлж, бүгд 23³ хүний орон тоотойгоор зохион байгуулан Иргэний Агаарын Тээврийн Удирдах Газрын харъянд ажиллуулж эхэлсэн байна.

Нийгмийн аюулаас хамгаалах яамны сайдын 1981 оны 2 дугаар сарын 21-ний 35 тоот тушаалаар иргэний агаарын тээврийг удирдах газрын ЦС ангийг тус газрын НАХ хэлтсийн харъяа болгож орлогч бөгөөд ЦС ангийн дарга удирдахаар зохион байгуулжээ. Цагдан сэргийлэх анги нь одоогийн МИАТ хувьцаат компаний буйран дээр айлын 4 өрөөтэй дан байшинд үйл ажиллагаа явуулж байсан байна.

Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн одоогийн байрлаж байгаа байр нь 1975-1980 онд эхэнд БНХАУ-ын Иргэний агаарын тээврийн төлөөлөгчийн газар байрлаж байсан байр бөгөөд 1980 онд ажилтнууд нь буцсан учир уг байрыг 60 000 төгрөгөөр үнэлэн /тэр үеийн ханшаар/ Хятадын элчин сайдын яамнаас худалдан авсанаар одоогийн Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн байр болсон түүхтэй юм байна. Тус хэлтэс 1981 онд анхны “Вартбург” машинтай болсон ажээ.

Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 190 тоот тогтоол ёсоор ЦСБ-ын ажилтнууд удаа жилийн нэмэгдлийг авах болсон нь ажилтны урам зоргийг сэргээжээ.⁴

Тухайн үед орон нутагт хоногийн 24 цагийн нислэг үйлдэж байснаас гадна хойд хөршөөс 7 хоногт 3 удаа олон улсын нислэг хийж байсан байна.

Тиймээс 1983 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 219 дүгээр тогтоолоор гэрээт цагдаагийн харуулыг татан буулгаж гэрээт эргүүлийг зохион байгуулжээ.

1990 онд ЦЕГ-ын даргын тушаалаар Нийслэлийн цагдаагийн газрын харъяа Иргэний агаарын тээврийн цагдаагийн тасаг болгож өөрчилсөн байна.

ЦЕГ-ын даргын 2005 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 433 тоот тушаалаар Нийслэлийн цагдаагийн газрын харъяа Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс болгоод дараа нь ЦЕГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 98 тоот тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын харъяа Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс болгон зэрэглэлийг ахиулсан байна.

³ дарга, ЭХЭС, Социалист өмч, мөрдөн байцаах албаны ахлах, жинхэнэ төлөөлөгч, мөрдөн байцаагч, сэргийлэн хамгаалах ахлах байцаагч, авто, галын байцаагч тус бүр 1, жижүүрийн офицер 3, автын зохицуулагч 1, сэргийлэгч 8, бичээч бичиг хэргийн эрхлэгч 1 гэсэн бүрэлдэхүүнтэй байжээ.

⁴ 114-115 дугаар хуудас

Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан ЦЕГ-ын даргын 2015 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/278 тоот тушаалаар хэлтсийн дарга 1, ахлах мөрдөн байцаагч, эдийн засгийн ахлах төлөөлөгч, хэв журмын ахлах байцаагч, замын цагдаагийн ахлах байцаагч тус бүр 1, хэлтсийн зохицуулагч 4, эргүүлийн цагдаа 9, мэдээлэл хүлээн авагч цагдаа 4, цагдаа-зохицуулагч 3, цагдаа-жолооч 2, бичиг хэргийн эрхлэгч, бичээч, архивч 1, үйлчлэгч 1, бүгд 25 алба хаагчийн орон тоотойгоор өргөтгөн зохион байгуулсан байна.

Өнөөдрийг хүртэл хугацаанд Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн даргаар 9-н хүн даргаар байсан бөгөөд одоо цагдаагийн хурандаа Г.Зоригтбаатар томиллогдон ажиллаж байна.

Нисэх буудлын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс нь цагдаагийн төрөл, мэргэжлийн албадтай хамтран ажиллаж ирсэн түүхэн хөгжлийг товчхон танилцуулбал.

Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч нар нь

1. 1993 оны 4-р сарын 23-нд Завхан аймгийн Марз ууланд сүйрсэн Ан-26 онгоцны хэрэг, 1989 онд Дорноговь аймгийн “Их хэт” суманд онгоцоор хүн дайран, амь насыг хохироосон Г-н хэрэг, 1997 оны 9-р сарын 21-нд Хөвсгөл аймгийн “Хохиур зураа” гэх газарт сүйрсэн Ан-24 онгоцны хэрэг.

2. 1997 оны 6-р сарын 19-нд Дундговь аймгийн Мандалговийн нисэх буудлын гадна сүйрсэн Ю-12 онгоцны хэрэг,

3. 1998 оны 5-р сарын 25-нд Хөвсгөл аймгийн “Байшинг” ууланд сүйрсэн Ю-12 онгоцны хэрэг.

4. 2001 оны 1-р сарын 23-нд Увс аймгийн Малчин сумын нутагт “Харгай зуух” гэдэг газарт сүйрсэн Ми-8 Т онгоцны хэрэг.

5. 2005 оны 11-р сарын 18-ны өдөр “Хангарьд” компаний Ан-38-120 маягийн агаарын хөлөг нь Улаанбаатар-Баруун-Урт чиглэлд нислэг үйлдэх үед онгоцны урд дугуй салж “Чингис хаан” олон улсын нисэх буудалд аваарын буулт хийсэн гэх мэт онц ноцтой, олон хүний амь нас хохирсон хэргүүдийг хууль зүйн дагуу түргэн шуурхай шийдвэрлэжээ.

Мөрдөн байцаах алба нь өнөөдөр нислэгийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний дэг журмыг сахиулахад туслах, гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчилтэй тэмцэж, түүнээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг шуурхай илрүүлж мөрдөн байцаалтыг цаг алдалгүй явуулж, хэрэг материалыг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэж байна.

Хэрэг бүртгэх байгууллага нь нислэг хөдөлгөөн, аюулгүй ажиллагаатай холбоотой зөрчил дутагдал нэг бүрийг бүртгэн шалгаж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол мэдээллийг хуульд заасан анхны хугацаанд шалгаж, хууль зүйн дагуу шийдвэрлэхэд анхаарч ажилладаг байна.

ЦЕГ-ын даргын 2008 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 649 дугаар тушаалаар хэв журмын ахлах байцаагч, жижүүрийн зохицуулагч хэрэг бүртгэлт явуулах эрх олгосон байна.

Эрүүгийн алба /эрүүгийн төлөөлөгч/ нь Монгол Улсын гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалт, бусад тушаал заавруудын хүрээнд ажлаа зохион явуулж, иргэний нисэхийн обектын нутаг дэвсгэрт эдийн засгийн болон албан тушаалын нууц далд аргаар үйлдэгдэж буй гэмт хэргүүдийг цаг алдалгүй гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг ашиглан илрүүлхийн зэрэгцээ, иргэний нисэхийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх, нисэх буудал, түүний орчимд тогтмол хяналт тавих, онцгой нөхцөл байдал бий болсон үед таслан зогсоох арга хэмжээ үүрэгтэй ба ИАТЦХ-ийн эрүүгийн төлөөлөгч нь үүргүүдийг гүйцэтгэхийн зэрэгцээ, иргэдийн амгалан тайван

байдлыг хангах, нийгэм, иргэдийн ашиг сонирхол, эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн төр ард түмний өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байна.

Хэв журмын алба нь 1979 оны 2 дугаар сард Иргэний агаарын тээврийн цагдан сэргийлэх гэрээт групп байгуулагдахад, сэргийлэн хамгаалах байцаагч хошууч Ж.Дагдангаар удирдуулсан 10 цагдаагийн бүрэлдэхүүнтэйгээр Хэв журмын хэсэг анх байгуулагджээ.

Тус ажил хариуцсан хэсэг нь ЦЕГ болон НЦГ-ын зорилтуудыг хэрэгжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах, гарсан гэмт хэргийг илрүүлж, таслан зогсоох, нислэгийн аюулгүй байдлыг хангах төр засгийн тэргүүн, гадаадын хүндэт зочдыг Монгол Улсад ирэх, явах үед хэв журмын хамгаалалт зохион байгуулж, аюулгүй байдлыг хамгаалах, иргэд аж ахуйн нэгж байгууллагаас өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэх, харъяа объектын гэрээт харуул хамгаалалт, архи согтууруулах ундаагаар үйлчлэх цэгүүдэд, хяналт тавих үүргүүдийг жижүүрийн 4 ээлжээр, эргүүлийн хэсгийг тодорхой удирдлагаар ханган ажиллаж.

Дотоодын цэргийн 0230-р ангид цэргийн алба хаасан хүмүүсээр эгнээгээ тэлж эргүүлийн цагдаагаар авч ажиллуулан олон улсын нисэх буудлын гадаад, дотоодын зорчигчдийн онгоцны талбайн постонд 24 цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж байжээ.

Хэв журмын алба хаагчдын ажил үүргээ нэр төртэйгээр гүйцэтгэж байснаас дурьдвал

1993 онд Завхан аймгийн Марз ууланд сүйрсэн, 1994 онд Хөвсгөл аймгийн Байшинт ууланд сүйрсэн онгоцны хэргүүдэд тус албаны офицер ахмад Н.Мөнхчулуун, эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ц.Мэндсайхан нар очиж хэргийн газрын хамгаалалтанд ажиллаж байв.

1992 онд гэрээт хэсгийн дарга, цагдаагийн хошууч Л.Тогтох Буянт-Ухаагийн хилээр Итали улсын 2 иргэн динозаврын 2 ширхэг өндөг, хоёр толгойтой хаш чулуун болон халтар манан хөөрөг, морины ясан хусуур, ясан зүү, эрдэнийн чулуу зэрэг үнэт зүйлсийг нуун авч гарахыг завдсан хэргийг илрүүлсэн байна.

Замын цагдаагийн хэсэг нь БНМАУ-ын Засгийн газрын 1979 оны 299 дүгээр тогтоолоор цагдан сэргийлэх гэрээт группэд өөрчлөлт орсоноор гэрээт замын цагдаагийн хэсэг байгуулагдах үндэс тавигджээ.

Замын цагдаагийн хэсэг нь “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахин хамгаалах, гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, төр засгийн тэргүүн, гадаадын хүндэт зочин төлөөлөгчдийг Монгол улсад ирэх, буцах үед аюулгүй байдлын хамгаалалтыг зохион байгуулах, хуулиар хүлээсэн бусад үүргээ биелүүлэн ажиллаж байна.

Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийг

1. БНМАУ-ын Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1979 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 67 тоот тушаалаар Нисэхийн Цагдан сэргийлэх группийг байгуулагдсан гэж үзэж болохоор байна.
2. 1941 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод байсан харуулын 3 суманг тус тус нэгтгэж харуулын дивизион байгуулж нисэх буудлын хамгаалалтыг хариуцуулсан, дээр дурьдсанчилан 1979 онд Нисэхийн Цагдан сэргийлэх групп анх байгуулсан, Нийгмийн аюулаас хамгаалах яамны сайдын 1981 оны 2 дугаар сарын 21-ний 35 тоот тушаалаар иргэний агаарын тээврийг удирдах газрын ЦС ангийг тус газрын НАХ хэлтсийн харъяа болгож цагдан сэргийлэх анги болгож өргөжүүлсэн, 1990 онд

Нийслэлийн цагдаагийн газрын харьяа Иргэний агаарын тээврийн цагдаагийн тасаг болгож өөрчилсөн, ЦЕГ-ын даргын 2005 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 433 тоот тушаалаар Нийслэлийн цагдаагийн газрын харьяа Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Цагдаагийн ерөнхий газрын харьяа Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс болгосон зэрэг үе шатуудар хөгжиж ирсэн байна.

3. Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаа нь нисэх буудлын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хэв журмын сахиулах ажлыг гүйцэтгэхдээ нисэх буудлын хөгжил дэвшилтэй нягт холбоотой хөгжиж ирсэн онцлогтой байна.